

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар
хот

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний
даатгалын сангаас олгох протез, ортопедийн
жишиг үнэ батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, ортопедийн жишиг үнийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар /Д.Баярболд/-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/507, А/112 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Х.БУЛГАНТУЯА

С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл
мэндийн сайдын, 2023
оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . / . . . дугаар хамтарсан тушаалын хавсралт

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН
ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН ЖИШИГ ҮНЭ**

Код	Протез, ортопедийн төрөл	Хэрэглэх заалт	Жишиг үнэ /төгрөгөөр/
01	Гавлын ясны протез	Гэмтлийн шалтгаантай гавал ясны цоорхойг хиймэл ясаар нөхөх	154 000
02	Нүдний хиймэл болор /уян, хатуу/	Гэмтлийн шалтгаантай нүдний болрын гэмтэл	181 500
03	Нулимсны сувгийн протез	Гэмтлийн шалтгаантай нулимсны сувгийн гэмтэл	121 000
04	Сонсголын ясны протез	Гэмтлийн шалтгаантай чамархай ясны гэмтэл	154 000
05	Хамрын ясны протез ПМП-01 /зөөлөн пластик/	Гэмтлийн шалтгаантай хамрын ясны гэмтэл	181 500
06	Шанааны ясны протез	Гэмтлийн шалтгаантай шанаан ясны бяцралт	1 452 000
07	Эрүүний ясны протез	Гэмтлийн шалтгаантай эрүүний ясны бяцралт, хугаралт	1 331 000
	Гарын протез:		
08	Нэг гарын протез	Гэмтлийн шалтгаантай мөрний үений тайралт	1 925 000
09	Бугалаганы протез	Гэмтлийн шалтгаантай тохойн үений тайралт	1 815 000
10	Бугалганаас урагш хийгдэх протез	Гэмтлийн шалтгаантай тохойн үений тайралт	1 540 000
11	Шуу, сарвууны протез	Гэмтлийн шалтгаантай шууны хэсгийн тайралт	1 100 000
	Хөлийн протез:		
12	Нэг хөлийн протез	Гэмтлийн шалтгаантай түнхний үений тайралт	1 760 000
13	Дунд чөмөгний протез	Гэмтлийн шалтгаантай дунд чөмөгний тайралт	1 705 000
14	Шилбэний протез	Гэмтлийн шалтгаантай шилбэний ясны тайралт	1 210 000
15	Тавхайн протез	Гэмтлийн шалтгаантай шагай, тавхайн тайралт	880 000
	Хиймэл үе:		
16	Нурууны хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай нурууны муруйлт	5 500 000
17	Түнхний хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай дунд чөмөгний хүзүү, толгойн хугарал, артроз -ил хугарлаас үүссэн үе үүсгэгч яснуудын үрэвсэл	4 400 000

		-архаг үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз /10-15 градус/	
18	Өвдөгний хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай -II, III, IV зэргийн артроз -үе үүсгэгч яснуудын хиймэл хугарал, -үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз /15-30 градус/	5 500 000
19	Тохой, шагайн хиймэл үе	Гэмтлийн шалтгаантай -II, III, IV зэргийн артроз -үе үүсгэгч яснуудын хиймэл хугарал, -үрэвслийн улмаас үүссэн контрактур, -регидность, -анкелоз	3 300 000
20	Хүзүү нурууны ясны металл бэхэлгээ	Гэмтлийн шалтгаантай хүзүү, нурууны гэмтлийн үед	990 000
21	Гэмтэл, түлэгдэлтийн сорви татанхайн үед	Гэмтэл, түлэнхийн шалтгаантай тулгуур, хөдөлгөөний эрхтэний хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан сорви, татанхай, зөөлөн эдийн дутмагшлын сорвижилтын улмаас сарвуу, хуруу, тавхайн идэвхитэй, идэвхигүй хөдөлгөөн алдагдсан /2-3 балл/	11 000 000
22	Гажиг засах бүх төрлийн гутал	Гэмтлийн шалтгаантай тавхайн согог, богиноссон хөлөнд	220 000
	Сонсголын аппарат:		
23	Сонсголын дижитал аппарат /нэг чихний/	Гэмтлийн шалтгаанаар хүлээн авах ба дамжуулах хэлбэрийн сонсгол бууралтын I үе /40-60 дб/, II,III үе /60-80 дб/, IV үе /80 дб-ээс дээш/	308 000
24	Сонсголын дижитал аппарат /хоёр чихний/	Гэмтлийн шалтгаанаар хүлээн авах ба дамжуулах хэлбэрийн сонсгол бууралтын I үе /40-60 дб/, II,III үе /60-80 дб/, IV үе /80 дб-ээс дээш/	616 000
	Бусад:		
25	Бионик хиймэл эрхтэн	Гэмтлийн шалтгаантай гарын тайралттай үед	15 000 000
26	Бионик хиймэл эрхтний засвар, үйлчилгээ	Гэмтлийн шалтгаантай гарын тайралттай үед	300 000

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл
мэндийн сайдын, 2023
оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . / . . . дугаар хамтарсан тушаалын хавсралт